



17th Story

Иудас Есүсийг зарсан нь

Garden Betrayal



Иудас Есүсийг зарсан нь!

– 17th Story –

Өгүүлэгч	Есүс шавь нартайгаа хамт Гетсеман гэдэг газар очоод тэдэнд айлдав.
Есүс	Энд залбирч байгаарай. Би тэнд очоод ганцаараа залбирна. Петр, Иаков, Иохан нар Надтай хамт явна.
Өгүүлэгч	Тэднийг явсны дараа Есүс зовж шаналж эхлэв.
Есүс	Сэтгэл минь үхтлээ зовж байна. Та нар энд байж Надтай хамт сэргэг байцгаа.
Петр	Мэдээж Эзэн минь
Иаков	Тэгье ээ, хамт байя
Өгүүлэгч	Есүс жаахан цааш яваад нүүрээрээ газар унаж сөхрөн залбирлаа.
Есүс	Эцэг минь, болж өгвөл Надаас энэ аягыг өнгөрүүлээч. Гэвч Миний хүслээр биш, харин Таныхаар болог.
Өгүүлэгч	Есүсийг ингэж залбиртал, Эзэний тэнгэрэлч нар дөхөж ирээд Есүсийг тайтгаруулав.
Габриел	Эзэн минь, тэсвэрлэхэд ямар бэрх болохыг мэдэж байна. Би төсөөлж ч чадахгүй нь. Энэ нь Эзэний хүсэл. Бүх хүмүүсийг аварна.
Есүс	Тийм ээ. Би энэ явдал заавал болох ёстойг мэдэж байна, өөр аргыг ч хүсэж байна. Гэвч өөр арга байхгүйг бас мэднэ. Дэлхийн аль ч улсад байсан, ямар ч хэлээр ярьдаг байсан хамаагүй, одоо бүх хүн бүгд Миний нэрээр эрх чөлөөтэйгээр Эзэний өмнө очих болно. Гэм нүглийн гинж дахин тэднийг хүлж чадахгүй. Яагаад гэвэл Би тэдний бүх гэм нүглийг үүрэн явж байна.
Өгүүлэгч	Есүс залбирлаа дуусгасаны дараа Петр, Иаков, Иоханы байгаа газар руу буцаж очоод хартал шавь нар нь унтаж байлаа.
Есүс	Та надтай нэг цаг ч гэсэн хамт сэргэг байж чадах нь уу? Сорилтонд орохгүйн тулд сэрүүн байж залбирагтун. Сэтгэл чинь хүсэвч махан бие чинь сул дорой юм.
Петр, Иаков, Иохан	Эзэн минь үнэхээр уучлаарай. Өршөөгөөрэй, Эзэн минь. Бид сэрээд залбиръя.



Өгүүлэгч

Есүс нөгөө л хэвээр гуниглан шаналж байлаа. Тиймээс дахин залбирахаар явав. Залбираад дахиад шавь нарынхаа байгаа газар руу буцаж ирэхэд, тэд бас л унтаж байлаа. Тэд ихэд нойрмоглох нүдээ ч нээж чадахгүй байв. Тиймээс Есүсийг тэднийг тэр чигт нь орхиод дахиад явж, яг адилхан залбирлаар дахин 3 удаа залбирав. Эцэст нь залбирлаа дуусгаад шавь нар дээрээ буцаж ирэн тэдэнд айлдав.

Есүс

Одоо ч унтсаар байна уу? Цаг нь болжээ. Хүний Хүү нүгэлтнүүдийн гарт тушаагдана. Бос, явцгаая. Намайг бариулагч ойрхон ирлээ.

Петр, Иаков, Иохан

Юу? Айн? Юу болох нь энэ вэ?

Өгүүлэгч

Есүсийг айлдаж байх үед 12 шавийн нэг Иудас дөхөж ирэв. Тэргүүн тахилчид болон ард түмний ахлагчдын явуулсан хүмүүс илд, шийдэм барин Иудастай хамт ирцгээв. Харин Иудас тэдэнд нууцаар дохион өгөн.

Искариотын Иудас

Миний үнссэн хүн бол Тэр хүн мөн учраас түүнийг барь.

Петр

Багшаа, юу болох нь энэ вэ?

Иаков

Эзэн минь??

Есүс

Анд минь, би хийх гэж байгаагаа хий.

Өгүүлэгч

Иудас Есүсийг үнстэл гэнэт олон дундаас хоёр хүн Есүсийг барьж баривчлах гэв. Тэр үед Есүстэй хамт байсан хүмүүсээс нэг нь гар сунган илдээ авч тэргүүн тахилчийн зарцыг цохиж чихийг нь тас цавчжээ.


Есүс

Болохгүй. Илдээ хуйнд нь хий. Илд авагч бүхэн илдээр хөнөөгдөнө. Арван хоёр легионоос олон тэнгэрэлчийг одоо Надад илгээхийг Би Эцэгээсээ гуйж чадахгүй гэж чи бодож байна уу? Энэ нь болох ёстой гэсэн Бичвэр тэгвэл яаж биелэгдэх билээ?

Та нар Намайг дээрэмчин барихтай адил санан, илд шийдэмтэй ирээ юү? Өдөр бүр та нартай сүмд сууж, зааж байхад минь та нар Намайг бариагүй. Харин энэ бүхэн нь эш үзүүлэгчдийн Бичвэр биелэгдэхийн тулд болов

Өгүүлэгч

Есүс энэ үгийг хэлэхэд цэргүүд Түүнийг дагуулж явав. Тэгээд шавь нар нь бүгд айцгаан Есүсийг орхиод зугтжээ. Есүсийг барьсан хүмүүс тэргүүн тахилч Каиаф руу Есүсийг чирч аваачсан. Тэнд хуулийн багш нар болон ахлагчид цуглараад Есүсийг хөнөөх худал гэрчлэл хайж байв.



Өгүүлэгч Олон хүмүүс гарч ирээд Есүсийн талаар худал гэрчлэл хийсэн боловч олигтой нотолгоо олж чадсангүй. Цаг хугацаа жаахан өнгөрсний дараа Каиаф Есүст хэлэв.

Каиаф Энэ хүмүүс таны эсрэг мэдүүлэг өгч байхад хариулах зүйл алга уу?

Өгүүлэгч Есүс юу ч хариулаагүйд тэргүүн тахилч, ахлагчид сэтгэл хангалуун бус байв.

Каиаф Тийм байх нь. Чи Бурханы Хүү Христ үү?

Есүс Та ч өөрөө хэллээ. Харин Би та нарт хэлье. Та нар үүнээс хойш Хүний Хүүг Хүчит Нэгэний баруун талд заларч, тэнгэрийн үүлэн дээр ирэхийг харах болно.

Өгүүлэгч Есүс энэ үгийг хэлэхэд тэргүүн тахилч уурлан дээлээ урж орхив.

Каиаф Тэр Бурханыг доромжлов. Бидэнд өөр гэрчийн хэрэг байна уу? Үзэгтүн, та нар сая доромжлол сонслоо. Та нар юу гэж бодож байна?

Ахлагчид, тэргүүн
тахилчид

Тэр заавал үхэх ёстой. Тэр нүгэл үйлдсэн.